

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ

I. Оршил

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг баталсан бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль 8 бүлэг, 41 зүйлтэй.

II. Хуулийн агуулга

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүнээр элссэн бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санааг дэмжиж улмаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад 1974 онд нэгдэн орсноос хойш хүний эрхийн талаарх 40 гаруй олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж соёрхон баталсан байна.¹ 2016 оны 1 дүгээр сарын байдлаар 273 олон улсын олон талт гэрээ, 1500 хоёр талт гэрээнд нэгдэн орсон байна. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулснаар хүний эрхийг хууль тогтоомжоор дамжуулан баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлсээр ирсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 оны 48/134 дүгээр тогтоолоороо батламжилсан "Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх зарчмууд буюу Парисын зарчмууд"-ын дагуу Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталсан бөгөөд 19 дэх жилдээ зарчмын шинжтэй өөрчлөлт оролгүйгээр хэрэгжиж байна. Тус хуульд 2002, 2003, 2011, 2015 онд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эдгээр нь гол төлөв бусад хууль тогтоомж батлагдан гарсантай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүд байна.

Хэдийгээр Парисын зарчмын дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан гэж үздэг ч Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Зохицуулах Хорооноос уг зарчимд бүрэн нийцүүлэх шаардлагатай буюу манай улсад "Хүний эрхийн Үндэсний байгууллага нь өөрийн байртай байх, тус байгууллагын үйл ажиллагааны төсвийг хараат бус байдлаар төлөвлөх, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох үйл явцыг ил тод, нээлттэй болгох зэрэг зөвлөмжүүдийн удаа дараа өгч байсан.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тавин долдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг баталж, 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр нэгдэн орохоор гарын үсэг зурж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан.

Тус Протоколд нэгдэн орсон улс орон бүр протокол хүчин төгөлдөр болсноос, эсхүл түүнийг соёрхон баталснаас, эсхүл түүнд нэгдэж орсноос хойш нэг жилийн дотор оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг болон түүнээс дээш байгууллагыг байгуулах, томилох ёстой бөгөөд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх нөхцөлөөр хангагдсан байх ёстой байдаг.

Монгол дээрх Протоколд нэгдэн орсноос хойш багагүй хугацаа өнгөрч байгаа ба НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хорооноос удаа дараа Монгол Улсын Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулах асуудлаар зөвлөмжүүдийг өгсөөр байна.

¹ "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь: Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойших хэрэгжилт. Хавсралт тайлан". ХЗҮХ. 2016 он. УБ хот. 125 дахь тал.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 5.2.11-д “Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тус тус заажээ.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн ба хэрэгжиж буй хуулийн зүйл, заалт нь бусад хууль тогтоомжтой уялдаа холбоо муутай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд төсөв хүрэлцээгүй, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, иргэдийн гомдлыг бүрэн дүүрэн шийдвэрлэхэд учир дутагдалтай, хүндрэл учруулдаг, гомдол шийдвэрлэх ажиллагааг хуульчлаагүй, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт сул, түүний хэрэгжүүлэх хуулийн хөшүүрэг хангалтгүй, жил бүр хүний эрхийн төлөв байдлын тайланг илтгэх процедур, үр дүнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэрэг практик хэрэглээнд гарч буй олон хүндрэлтэй асуудал байна гэж дүгнэсэн.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлагатай байна гэж хууль санаачлагчаас үзжээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг боловсронгуй болгох, хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараахь асуудлуудыг хуулийн төсөлд тусгаж, УИХ-д өргөн мэдүүлсэн. Үүнд:

- 1.Нэр томъёоны тодорхойлолтыг дэлгэрүүлж тодорхой болгоно;
- 2.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэн олон нийтийн оролцоотойгоор ил тод, нээлттэй зохион байгуулахаар тусгана;
- 3.Хүний эрхийн үндэсний тогтолцооны бүрдэл, байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулна;
- 4.Комиссын үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх хангалттай төсөвтэй байхаар тусгах ба хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, хөхиүлэн дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төслийг боловсруулж, хянуулж, батлуулах процедурыг тодорхой болгож тусгана;
- 5.Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бэлтгэх, олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулах, тайлагнах, хэрэгжүүлэх үйл явцыг боловсронгуй болгоно;
- 6.Хамтын зарчмаар шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх Комиссын хуралдааны журмыг нарийвчилна;
- 7.Комисст гаргасан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гишүүнийг төлөөлөн ажиллаж буй тухайн чиг үүргийг хэрэгжүүлж буй Комиссын ажлын албаны албан хаагчдын мэдээлэл цуглуулах ажиллагааны явцад эдлэх эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулна;

8.Комиссоос хүргүүлж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэхгүй удаашруулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар шуурхай, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлага тооцох үндэслэлийг тодорхой болгоно;

9.Комисст ирүүлсэн иргэний болон эрүүгийн хэрэг маргаантай холбоотой гомдлыг харьяаллын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж буй зохицуулалтад зөрчил, захиргааны хэрэг маргааныг нэмж тусгана;

10.Бие даасан, хараат бус эрүү шүүлтийн эсрэг үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг Комиссын дэргэд бий болгохоор тусгана.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх бөгөөд энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

II.Хуулийн бүтэц

№	Бүлэг	Зохицуулсан харилцаа
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 2 дугаар зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль тогтоомж 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2	Хоёрдугаар бүлэг Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо	4 дүгээр зүйл.Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчим 5 дугаар зүйл.Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо 6 дугаар зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 7 дугаар зүйл.Комиссын чиг үүрэг 8 дугаар зүйл.Комиссын үйл ажиллагааны үндсэн зарчим 9 дүгээр зүйл.Комисс Монгол Улсын Их Хуралтай харилцах 10 дугаар зүйл.Комисс Засгийн газартай харилцах 11 дүгээр зүйл.Комисс прокурорын байгууллагатай харилцах 12 дугаар зүйл.Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох 13 дугаар зүйл.Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 14 дүгээр зүйл.Комиссын гишүүн тангараг өргөх 15 дугаар зүйл.Комиссын гишүүнийг чөлөөлөх, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах 16 дугаар зүйл.Комиссын хуралдаан 17 дугаар зүйл.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл
3	Гуравдугаар бүлэг Комиссын гишүүний бүрэн эрх	18 дугаар зүйл.Комиссын гишүүний бүрэн эрх 19 дүгээр зүйл.Комиссын даргын бүрэн эрх
4	Дөрөвдүгээр бүлэг Гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх ажиллагаа	20 дугаар зүйл.Комисст гомдол, мэдээлэл гаргах эрх 21 дүгээр зүйл.Гомдол, мэдээлэл гаргах хэлбэр 22 дугаар зүйл.Гомдол, мэдээлэлд тавих шаардлага 23 дугаар зүйл.Гомдол, мэдээлэл гаргах болон хянан шийдвэрлэх хугацаа 24 дүгээр зүйл.Комиссын гишүүний гомдол, мэдээлэл хүлээн авахтай холбогдсон бүрэн эрх

		25 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шалгахтай холбогдсон бүрэн эрх 26 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шийдвэрлэхтэй холбогдсон бүрэн эрх
5	Тав дугаар бүлэг Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж	27 дугаар зүйл. Комиссын гишүүн шаардлага, зөвлөмж гаргах 28 дугаар зүйл. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг биелүүлэх
6	Зургадугаар бүлэг Комиссын ажлын зохион байгуулалт	29 дүгээр зүйл. Комиссын Тамгын газар 30 дугаар зүйл. Иргэний нийгмийн зөвлөл
7	Долдугаар бүлэг ЭРҮҮ Шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа	31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 32 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг 34 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх 35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж 36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж
8	Наймдугаар бүлэг Комиссын болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн баталгаа	37 дугаар зүйл. Улс төрийн баталгаа 38 дугаар зүйл. Эдийн засаг, нийгмийн баталгаа 39 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа 40 дүгээр зүйл. Аюулгүй байдлын баталгаа 41 дүгээр зүйл. Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл

IV.Хуулийн зарим зохицуулалтаас

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн зорилт /1 дүгээр зүйл/

1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжихтэй холбогдсон харилцааг.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /3 дугаар зүйл/

1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1/**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс**” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг;

2/“эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчим /4 дүгээр зүйл/

1.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөгжлийн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн байна.

2.Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэнэ гэж заасан байгууллага хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчмыг удирдлага болгоно.

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо /5 дугаар зүйл/

1.Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэнэ.

2.Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг оролцуулж болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /6 дугаар зүйл/

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /цаашид “Комисс” гэх/ улсын төсвөөс санхүүжнэ. Комиссын дарга жилийн төсвийн төслийг төлөвлөн Улсын Их Хурлын даргад хүргүүлэх бөгөөд төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ. Комиссын дарга Байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

2.Комиссын төсөв үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээч томилон ажиллуулахад шаардагдах зардал болон бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана.

Комиссын чиг үүрэг /7 дугаар зүйл/

1.Комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;

2/хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;

3/хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;

4/хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;

5/хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;

6/хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

7/хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

8/шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

9/жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10/төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;

11/Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх.

Комиссын үйл ажиллагааны үндсэн зарчим /8 дугаар зүйл/

1.Комисс үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

1/хүний эрх, эрх чөлөөг дээдлэх;

2/хүртээмжтэй байх;

3/шударга, ил тод байх;

4/хараат бус, бие даасан байх.

Комисс Монгол Улсын Их Хуралтай харилцах /9 дүгээр зүйл/

1.Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

2.Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргана.

Комисс Засгийн газартай харилцах /10 дугаар зүйл/

1.Засгийн газар Комиссын төсвийн төслийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /цаашид “Комисс” гэх/ улсын төсвөөс санхүүжнэ. Комиссын дарга жилийн төсвийн төслийг төлөвлөн Улсын Их Хурлын даргад хүргүүлэх бөгөөд төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ. Комиссын дарга Байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ, Комиссын төсөв үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээч томилон ажиллуулахад шаардагдах зардал болон бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана гэж заасан журмын дагуу улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгана.

2.Комиссын дарга Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд Ерөнхий сайдын хүсэлтээр хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар зөвлөх эрхтэйгээр оролцож болно.

3.Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалд санал өгсөн тохиолдолд Комиссын даргыг хуралдаанд байр сууриа илэрхийлэхээр оролцуулж болно.

4.Комисс олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орох асуудлаар байр сууриа илэрхийлэх, Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийг хангуулах Засгийн газрын илтгэлд санал, зөвлөмж өгч болно.

Комисс прокурорын байгууллагатай харилцах /11 дүгээр зүйл/

1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана.

Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох /12 дугаар зүйл/

1.Комисс таван гишүүнтэй байна.

2.Комиссын гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна:

1/хууль зүйн өндөр мэргэшилтэй;

2/хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай.

3.Гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Хууль зүйн байнгын хорооноос Комиссын гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

4. Комиссын гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна гэж заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд

мэдээлснээс хойш 30 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ.

5.Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг байгуулж, 15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан иргэдээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор нэр дэвшүүлж, Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлнэ.

6.Хууль зүйн байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэж, Комиссын гишүүнээр томилох саналаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

7.Комиссын гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол 14 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан иргэдээс дарааллын зарчмаар өөр иргэний нэрийг дэвшүүлнэ.

8.Нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол тухайн иргэнийг дахин нэр дэвшүүлэхгүй.

9.Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд Комисс таван гишүүнтэй байна гэж заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.

10.Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурал 60 хоногийн дотор энэ хуульд заасны дагуу нөхөн томилно.

11.Комиссын гишүүн томилогдохоосоо өмнө өөр ажил, албан тушаал эрхэлж байсан бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөнө.

12.Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Хууль зүйн байнгын хороо батална.

Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа /13 дугаар зүйл/

1.Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна.

2.Комиссын гишүүний бүрэн эрх Улсын Их Хурлаас томилсноор эхэлж, дараагийн Комиссын гишүүнийг томилсноор дуусгавар болно.

3.Комиссын гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.

5.Комиссын даргын түр эзгүйд Комиссын бүрэлдэхүүнд хамгийн удаан жил ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн зэрэг хангаж байгаа бол тэдгээрийн хамгийн ахмад гишүүн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

Комиссын гишүүн тангараг өргөх /14 дүгээр зүйл/

1.Комиссын гишүүн томилогдсоноос хойш 30 хоногийн дотор “Би Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх,

эрх чөлөөг дэмжих, хамгаалах үүргээ чин шударгаар биелүүлэхээ батлан тангараглая.” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.

2.Комиссын гишүүний тангараг өргөх ёслолыг Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

Комиссын гишүүнийг чөлөөлөх, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах /15 дугаар зүйл/

1.	Улсын Их Хурал Комиссын гишүүнийг дараах тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлнө:	1/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэрээ дэвшүүлэхээр хүсэлт гаргасан; 2/өөр ажил, албан тушаалд шилжин ажиллах болсон; 3/эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос өөрөө хүсэлт гаргасан; 4/хуульд өөрөөр заагаагүй бол төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн.
2.	Комиссын гишүүн эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан, эсхүл энэ хуулийн 39.1-д заасны дагуу баривчлагдсан бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал эрх бүхий байгууллагын саналыг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.	
3.	Комиссын гишүүн гэмт хэрэгт холбогдолгүй, гэм буруугүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн түүний бүрэн эрхийг сэргээж Улсын Их Хурал тогтоол гаргана.	
4.	Комиссын гишүүн гэмт хэрэг үйлдсэн талаар шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсноор түүнийг Улсын Их Хурал албан тушаалаас нь огцруулна.	

Комиссын хуралдаан /16 дугаар зүйл/

1.Комиссын хуралдааныг сар тутам хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Комиссын дарга ээлжит бус хуралдааныг тухай бүр зарлан хуралдуулж болно.

2.Комисс хуралдааны дэгийг өөрөө тогтооно.

3.Комиссын чиг үүрэгт хамаарах дараах асуудлыг Комиссын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэнэ:

1/Комиссын Тамгын газрын дүрмийг баталж, орон тоо, цалингийн санг Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан тогтоох;

2/Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн бүтэц, агуулга, илтгэлээр өгөх санал, зөвлөмжийг хэлэлцэж, шийдвэрлэх;

3/Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх санал, зөвлөмжийг хэлэлцэх;

4/Комиссын стратеги болон үйл ажиллагааны жил, улирал, сарын ажлын төлөвлөгөөг тодорхойлох;

5/хяналт шалгалт, судалгааны нэгдсэн дүнг хэлэлцэх;

6/хүний эрхийн асуудлаар Комиссын нэгдмэл байр суурийг тодорхойлох.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл /17 дугаар зүйл/

1.Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

2.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн сэдвийг Комиссын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолд заасан үүргийн дагуу Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг Улсын Их Хуралд жил бүр илтгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ КОМИССЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

Комиссын гишүүний бүрэн эрх /18 дугаар зүйл/

1.Комиссын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүсэлтээр шалгалт хийх;

2/хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтнаас бүх төрлийн баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, шаардлагатай мэдээлэл, судалгаа гаргуулан авах;

3/хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх.

2.Комиссын гишүүн хүний эрхийг зөрчсөн талаарх мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж болно.

Комиссын даргын бүрэн эрх /19 дүгээр зүйл/

1.Комиссын дарга дараах эрх, үүрэгтэй:

1/Комиссыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

2/Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын даргын хүсэлтээр оролцох;

3/Комисст ирсэн гомдол, мэдээллийг шийдвэрлүүлэхээр Комиссын гишүүдэд хуваарилах;

4/Комиссын Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх;

5/Комиссын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

6/Комиссын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх;

7/Комиссын хуралдааныг товлож, удирдан хуралдуулах;

8/Комиссын цахим шуудан болон утсаар гомдол, мэдээлэл хүлээж авах, хариу өгөх журмыг батлах;

9/Комиссын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг батлах;

10/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Комисст гомдол, мэдээлэл гаргах эрх /20 дугаар зүйл/

1.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй.

2.Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил гомдол, мэдээлэл гаргах эрх эдэлнэ.

3.Хүүхэд болон иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим, эсхүл бүрэн бус чадамжтай хүн өөрт хамаарах аливаа асуудлаар бие даан, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээрээ дамжуулан гомдол, мэдээлэл гаргаж болно.

4.Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүний хууль ёсны төлөөлөгч гомдол, мэдээлэл гаргаж болно.

5.Ашгийн төлөө бус хуулийн этгээд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй гэж заасан эрхийг эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол, мэдээлэл гаргана.

6. Хүүхэд болон иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим, эсхүл бүрэн бус чадамжтай хүн өөрт хамаарах аливаа асуудлаар бие даан, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээрээ дамжуулан гомдол, мэдээлэл гаргаж болно, Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүний хууль ёсны төлөөлөгч гомдол, мэдээлэл гаргаж болно, Ашгийн төлөө бус хуулийн этгээд энэ хуулийн 20.1-д заасан эрхийг эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол, мэдээлэл гаргана гэж тус тус заасан төлөөлөгч нь өөрийн бүрэн эрхийг нотолсон баримт бичигтэй байна.

Гомдол, мэдээлэл гаргах хэлбэр /21 дүгээр зүйл/

1.Гомдол, мэдээллийг төрийн албан ёсны хэлээр бичгээр, эсхүл амаар гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол, мэдээлэл гаргаж болох бөгөөд монгол хэлээр орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

2.Амаар биечлэн гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахдаа тэмдэглэл үйлдэж, гомдол, мэдээлэл гаргагчаар гарын үсэг зуруулна. Хэрэв гомдол, мэдээлэл гаргагч нь бичиг, үсэг мэдэхгүй болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, гомдол, мэдээллийг хүлээн авна.

3.Гомдол, мэдээллийг Комиссын цахим шуудан, эсхүл тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан гаргаж болно.

Гомдол, мэдээлэлд тавих шаардлага /22 дугаар зүйл/

1.	Гомдол, мэдээлэлд дараах зүйлийг тусгасан байна:	<p>1/Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах;</p> <p>2/гомдол, мэдээлэл гаргагч эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх;</p> <p>3/зөрчигдсэн эрх, эрх чөлөө, болсон нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, нотлох баримтыг хавсаргасан байх;</p> <p>4/гомдол, мэдээлэлд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлага, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргах.</p>
2.	Комисс мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахгүй.	

Гомдол, мэдээлэл гаргах болон хянан шийдвэрлэх хугацаа /23 дугаар зүйл/

1.Гомдол, мэдээлэл гаргагч Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн даруй гомдол, мэдээллээ гаргана. Комисс гомдол, мэдээлэл гаргагчийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн, эсхүл зөрчигдсөнийг мэдсэн өдрөөс хойш хоёр жил хүртэлх хугацаанд гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авна.

2.Комисс гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх ба нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай бол Комиссын дарга 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Комиссын бүрэн эрхэд хамаарахгүй гомдол, мэдээллийг ажлын гурван өдөрт багтаан холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

Комиссын гишүүний гомдол, мэдээлэл хүлээн авахтай холбогдсон бүрэн эрх /24 дүгээр зүйл/

1.Комиссын гишүүн гомдол, мэдээлэл хүлээн авах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан үзэх;

2/ гомдол, мэдээлэл гаргагч эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх заасан шаардлагыг хангаагүй гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах;

3/гомдол, мэдээлэл гаргагчид зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар тайлбарлах.

Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шалгахтай холбогдсон бүрэн эрх /25 дугаар зүйл/

1.Комиссын гишүүн гомдол, мэдээлэл шалгах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/гомдол, мэдээлэл гаргасан болон холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлагаас гомдол, мэдээллийн талаар бичгээр болон амаар тайлбар авах;

2/гомдол, мэдээлэл гаргагч, холбогдох иргэнийг дуудан ирүүлэх;

3/гомдол, мэдээлэлтэй холбоотой асуудлаар аль ч байгууллага, объект, хуулийн этгээдэд саадгүй нэвтрэн орж, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзах;

4/шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах;

5/тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

6/байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дангаар, эсхүл төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт хийх;

7/хуульд заасан журмын дагуу төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцтай саадгүй, даруй танилцах.

Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шийдвэрлэхтэй холбогдсон бүрэн эрх /26 дугаар зүйл/

1.	Комиссын гишүүн гомдол, мэдээлэл шийдвэрлэх чиглэлээр дараах	1/хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх; 2/иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах; 3/хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн
----	--	--

	<p>бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах этгээдэд холбогдох хариуцлага оногдуулах тухай саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;</p> <p>4/талуудыг эвлэрүүлэн зуучлах;</p> <p>5/гомдол, мэдээлэл нь эрүү, зөрчлийн шинжтэй гэж үзвэл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;</p> <p>6/зөрчлийг арилгах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар гомдол, мэдээллийг шилжүүлэх, биелэлтийг шаардах;</p> <p>7/эрүү шүүлт явуулсан байж болзошгүй албан хаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлыг Улсын ерөнхий прокурорт уламжлах.</p>
2.	<p>Комиссын гишүүн албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцыг чандлан хадгална.</p>	
3.	<p>Комиссын гишүүн гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуульд заасан журмын дагуу гомдол, мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэнэ.</p>	

ТАВДУГААР БҮЛЭГ КОМИССЫН ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ

Комиссын гишүүн шаардлага, зөвлөмж гаргах /27 дугаар зүйл/

1. Комиссын гишүүн нь бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлага, зөвлөмж гаргана.
2. Комиссын гишүүн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлнэ.
3. Комиссын гишүүн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлнэ.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг биелүүлэх /28 дугаар зүйл/

1. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.
2. Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд шаардлагыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэнэ. Комиссын гишүүн хүний эрхийн зөрчил, хэрэгжүүлэх арга хэмжээний онцлогоос хамааран хариу мэдэгдэх хугацааг өөрөөр тогтоож болно.
3. Комиссын гишүүний шаардлагын дагуу арга хэмжээ аваагүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг нь зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах үндэслэл болно.

4.Комиссын гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ аваагүй нь албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, биелүүлэх хүртэлх хугацаанд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, үйл ажиллагааг нь түр зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах үндэслэл болно.

5.Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, олон нийтэд мэдээлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ КОМИССЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Комиссын Тамгын газар /29 дүгээр зүйл/

1.Комисс Тамгын газартай байх бөгөөд Тамгын газар нь Комиссын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

2.Тамгын газар нь Комиссын чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх газар, хэлтэстэй байна.

3.Комиссын Тамгын газрын дарга, ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

4.Комиссын Тамгын газар нь орон нутагт Комиссын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байна.

5.Комиссын орон нутаг дахь ажилтны үйл ажиллагаанд Тамгын газар хяналт тавина.

6.Комиссын Тамгын газрын холбогдох ажилтан Комиссын гишүүний бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс дараах байдлаар төлөөлөн хэрэгжүүлнэ:

1/гомдол, мэдээлэл хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх;

2/Комиссын гишүүний удирдамж, чиглэлийн дагуу гомдол, мэдээллийг шалгах, баримтжуулах;

3/.гомдол, мэдээллийг шалгаад тогтоогдсон нөхцөл, байдлыг саналын хамт Комиссын гишүүнд танилцуулах;

4/.Комиссын гишүүний удирдамж, чиглэлийн дагуу хүний эрхийн хяналт шалгалт явуулах;

5/Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

Иргэний нийгмийн зөвлөл /30 дугаар зүйл/

1.Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна.

2.Иргэний нийгмийн зөвлөлийн олон талт төлөөллийг хангахдаа хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачийг оролцуулна.

3.Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

1/хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач байх;

2/хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх;

3/улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

4.Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг Комиссын хуралдаанаар баталж, мөрдүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа /31 дүгээр зүйл/

1.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хэрэгжүүлнэ.

2.Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно.

3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.

4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн /32 дугаар зүйл/

1.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр хууль зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, Монгол Улсын иргэнийг зургаан жилийн хугацаатай томилно.
2.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр хууль зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, Монгол Улсын иргэнийг зургаан жилийн хугацаатай томилно гэж заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ.
3.	Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг байгуулж, 15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад тэнцэж, хамгийн өндөр оноо авсан иргэнийг нэр дэвшүүлж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.
4.	Хууль зүйн байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр томилох саналаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
5.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журмын дагуу 14 хоногийн дотор өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

6.	Нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй бол тухайн иргэнийг дахин нэр дэвшүүлэхгүй.
7.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурал 60 хоногийн дотор энэ хуульд заасны дагуу нөхөн томилно, Комиссын гишүүн томилогдохоосоо өмнө өөр ажил, албан тушаал эрхэлж байсан бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөнө гэж заасан зохицуулалт, Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Хууль зүйн байнгын хороо батална гэж заасан журам нэгэн адил хамаарна.
8.	Улсын Их Хурал Комиссын гишүүнийг дараах тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлнө гэж заасан үндэслэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг хугацаанаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг /33 дугаар зүйл/

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх;

2/ олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах;

3/ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах;

4/ хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах.

Тайлбар: Энэ хуульд заасан “**бүх газарт**” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх /34 дүгээр зүйл/

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх;

2/ хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах;

3/ аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газар, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний талаарх бүх төрлийн мэдээллийг аль ч үед гаргуулан авах;

4/ аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт ажиллах явцдаа аюулгүй байдлаа хангуулах;

5/ аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газрын нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах;

6/эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

7/эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, олон нийтэд тогтмол мэдээлэх;

8/эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

9/эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг томилох, чөлөөлөх;

10эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

11/эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж /35 дугаар зүйл/

1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөвлөмж хүргүүлнэ.

2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

3.Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд нь зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэнэ.

4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж /36 дугаар зүйл/

1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана.

2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дарга, ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах ба зөвхөн аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах; хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулна гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ **КОМИССЫН БОЛОН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН** **ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА**

Улс төрийн баталгаа /37 дугаар зүйл/

1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон Тамгын газрын албан хаагч нь улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Гишүүн албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

2.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

Эдийн засаг, нийгмийн баталгаа /38 дугаар зүйл/

1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

2.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, зэрэглэлд тохирсон цалин хөлс авна.

Хууль зүйн баталгаа /39 дүгээр зүйл/

1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ. Бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон зөрчлийн баривчлах шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

2.Хуульд зааснаас бусад тохиолдолд Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг ажлаас чөлөөлөх, огцруулах, эсхүл өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

3.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх чиглэлээр захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

4.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Аюулгүй байдлын баталгаа /40 дүгээр зүйл/

1.	Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн, эсхүл ийм нөхцөл байдал гарч болзошгүй тохиолдолд цагдаагийн байгууллага аюулгүй байдлыг хангана.
2.	Хүний эрхийн хяналт шинжилгээ, хяналт шалгалтын үеэр Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Тамгын газрын ажилтнуудын аюулгүй байдлыг шалгалтад хамрагдаж байгаа байгууллага, албан тушаалтан хангана.
3.	Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл /41 дүгээр зүйл/

1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно:

1/сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад энэ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

2/энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах;

3/албан үүрэгтэй нь холбогдож мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцыг задруулах;

4/бусад улсын хүний эрхийн үндэсний болон олон улсын байгууллага, олон улсын гэрээгээр харилцан тохиролцсоноос бусад гадаад улс, тэдгээрийн иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний санхүүжилтээр гадаад улсад зорчих.

-----oO-----

**Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай
хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актууд**

№	Журмын нэр	Хуулийн заалт	Батлах субъект
1	Төрийн алба хаагчийн тангараг өргөх журам	ТАТХ-ийн 36.2	Монгол Улсын Ерөнхийлөгч батална
2	Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журам	32.7	Хууль зүйн байнгын хороо батална
3	Комисс нь бэлгэдэлтэй байж болох бөгөөд түүнийг хэрэглэх журмыг	6.4	Комиссын хуралдаанаар батална
4	Комиссын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх;	19.1.6	Комиссын дарга
5	Комиссын цахим шуудан болон утсаар гомдол, мэдээлэл хүлээж авах, хариу өгөх журам	19.1.8	Комиссын дарга
6	Комиссын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг	19.1.9	Комиссын дарга
7	эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам	34.1.11	Комиссын дарга

-----oOo-----